



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 5/28

Өмнөдэлгэр сум

**Туршилтын хугацаагаар ажилд
түр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоол, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Хоринзургаа дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ган-Эрдэнийн Нарангаравыг Засаг даргын Тамгын газрын архив, бичиг хэргийн ажилтнаар 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн туршилтын хугацаагаар түр томилсугай.

2.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандартыг чанд мөрдөн, албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлж, идэвх санаачилгатай ажиллахыг Г.Нарангаравт үүрэг болгосугай.

3.Г.Нарангаравт албан тушаалын тодорхойлолтыг танилцуулж, арга зүйн зөвлөгөө өгч, удирдлагаар ханган ажиллахыг нийгмийн бодлогын мэргэжилтэн Т.Эрдэнэтуяад хариуцуулсугай.

4.Г.Нарангаравын үндсэн цалин ТҮМ-3 1,283,000 (нэг сая хоёр зуун наян гурван мянга) төгрөгөөр, орон нутгийн нэмэгдлийг 60 хувиар тооцож цалинжуулахыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Л.БАЯРМАА

